



**Ү А Г**  
Үндэсний аудитын газар

**Замын цагдаагийн газрын  
үйл ажиллагааны үр дүн, үр  
нөлөөт байдал**



**Эрсдэлээс хамгаалах дотоод  
хяналтын тогтолцоо шаардагдаж байна**

**УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан**

Улаанбаатар 2006 он

# Агуулга

	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</b>	3
	<b>Зөвлөмж</b>	4
	<b>Бүлэг 1</b>	
<b><u>Тайланг бэлтгэсэн:</u></b>	<b>Үйл ажиллагааны хяналтын тогтолцоог хэтийн төлөвлөгөөндөө тодотгох шаардлагатай байна</b>	
<b>ҮАГ-ын Нэгдүгээр газар</b>	Танилцуулга	5
<i>Тэргүүлэх аудитор Д.Ганбилэг</i>	• Үйл ажиллагааны хяналтын тогтолцоог хэтийн төлөвлөгөөндөө тодотгох шаардлагатай байна	6
<i>Аудитын менежер Ж.Батсайхан</i>	• Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсронгуй болгож, гарч болох эрсдэлийг тодорхойлох шаардлагатай байна	7
<i>Ахлах аудитор С.Сэрчхорол</i>		
<i>Аудитор С.Анруш Х.Баярмаа</i>		
<i>Шинжээч Ц..Эрдэнэчулуун</i>		
<b>2006 оны 6 дугаар сар</b>		
	<b>Бүлэг 2</b>	
<b>Тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:</b>	<b>Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах боломж байна</b>	
<b><u><a href="http://www.mnao.pmis.gov.mn">www.mnao.pmis.gov.mn</a></u></b>	Танилцуулга	10
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	• Иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээгээ тодорхойлон, хөнгөн шуурхай болгох боломжийг судалж, бүтцээ тодорхой болгох шаардлагатай байна	11
<b>ХАЯГ:</b>	• Жолоочийн эрх олгох шалгалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна	13
<i>Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</i>	• Нийслэлийн автозамын хөдөлгөөнийг зохицуулах үйл ажиллагаанд хамааралтай	14

---

# Агуулга

---

байгууллагуудын хоорондын  
ажлын уялдаа хангалтгүй байна

## Бүлэг 3

---

### **Санхүүжилтийн эх үүсвэрийн хоёрдмол байдлыг цэгцлэх хэрэгтэй байна**

	16
Танилцуулга	17
• Шатахууны зардлыг давхардуулан олгожээ	18
• Орлого нэмэгдүүлэх боломж байна	19
• Нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтлөөгүй байна	

---

# Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Замын цагдаагийн газрын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Цагдаагийн ерөнхий газрын харъяа Замын цагдаагийн газрын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөт байдалд дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ.

- ЗЦГ-ын үйл ажиллагааны хяналтын тогтолцоо, түүний үр нөлөө
- ЗЦГ иргэдийн хэрэгцээг хангаж чадаж байгаа эсэх
- ЗЦГ-ын санхүүгийн нөөцийн үр ашиг, үр нөлөөт байдал

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй, Английн Үндэсний аудитын газрын тэргүүлэх аудитор Сюзан Свинглерийн боловсруулсан “Гүйцэтгэлийн аудитын гарын авлага”-ыг ашиглав.

Түүнчлэн бага оврын автобусны үйлчилгээ эрхлэгчдийн “Алдар үйлс” холбоотой хамтран 389 жолоочоос санал асуулга авч, дүнг нэгтгэв.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ЗЦГ, түүний харъяа тасаг, хэлтэс, Багануур, Налайх дүүргийн Замын цагдаагийн тасаг, алба хамрагдлаа.

# ЗӨВЛӨМЖ

## **Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаярт**

**Зөвлөмж 1:** Автозамын хөдөлгөөнд саад учруулж байгаа автомашиныг ачих журмын хэрэгжилтийг шалгаж, дүнг олон нийтэд мэдээлэх;

**Зөвлөмж 2:** Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад цагдаагийн ажилтнуудын унааны зардлын хөнгөлөлтийг нөхөхөд зориулж батлагдсан хөрөнгийг цагдаагийн ажилтнуудад олгох асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

**Зөвлөмж 3:** ЗЦГ-ын санхүүжилтийн эх үүсвэрийг нэг мөр болгох асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

## **ЦЕГ-ын дарга, хошууч генерал Д.Сандаг-Очирт**

**Зөвлөмж 4:** ЗЦГ-ын бүтэц, зохион байгуулалтыг хянаж, оновчтой болгох;

**Зөвлөмж 5:** "Ай-Эс-Си" ХХК-ийн хэвлэж байгаа жолоочийн үнэмлэхийг төрийн мэдэлд авах асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

## **Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Батбаярт**

**Зөвлөмж 6:** Автозамын хөдөлгөөний зохицуулалт хийдэг байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулж, Улаанбаатар хотын замын түгжрэлийг багасгах бодлого боловсруулах;

## **ЗЦГ-ын дарга, хурандаа Ц.Амгаланбаярт**

**Зөвлөмж 7:** Өөрийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын чиг үүргийг оновчтой зохион байгуулах.

**Зөвлөмж 8:** Авилгал, залилан, сонирхлын зөрчил, хүнд суртал байж болох эрсдэлийн судалгаа хийж, урьдчилан сэргийлэх механизм бүрдүүлэх.

**Зөвлөмж 9:** Үндсэн үйл ажиллагаанаас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж төсөвт тусгуулах;

**Зөвлөмж 10:** Нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлан тэнцлийг аккрузал сууриар бүртгэн тайлагнаж байх.

# Бүлэг 1

Үйл ажиллагааны хяналтын тогтолцоог хэтийн төлөвлөгөөндөө тодотгох шаардлагатай байна



## 1.Танилцуулга

1.1 Замын цагдаагийн газрын даргын 2003 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 99 дүгээр тушаалаар Замын цагдаагийн албаны үйл ажиллагааны 2004 – 2008 оны төлөвлөгөөг баталжээ.

1.2 Замын цагдаагийн алба үйл ажиллагааны 2004 – 2006 оны хэтийн төлөвлөгөөндөө стратегийн 9 зорилт дэвшүүлж, тэдгээрийг биелүүлэх арга хэмжээг боловсруулсан байна.

1.3 Үйл ажиллагааны бизнес болон хэтийн төлөвлөгөөндөө тодорхойлсон эрхэм зорилго:

**Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сахин хамгаалах эрхэм үүргээ мэргэжлийн өндөр түвшинд чанартай шуурхай биелүүлж, эрдэнэт хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эд материалын хохирлыг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэхэд оршино.**

1.4 Жилийн зорилт, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөө гаргаж, тэдгээрийн биелэлтийг дүгнэж иржээ.


**Үйл ажиллагааны хяналтын тогтолцоог хэтийн төлөвлөгөөндөө тодотгох шаардлагатай байна**

1.5 ЗЦГ-ын бизнес төлөвлөгөөний 4 дүгээр зорилтын 1-д дотоод хяналтын талаар тусгажээ.

Байгууллагын хэмжээнд явуулж байгаа бодлого, хэрэгжиж байгаа төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх.

1.6 Тус газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий загварыг бизнес төлөвлөгөөнд дөрвөн чиглэлтэй байхаар тусгасан боловч Цагдаагийн ерөнхий газрын даргын 2005 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Замын цагдаагийн газрын бүтцийг үзэхэд мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн нэгжгүй, Тамгын хэлтэст хяналт шалгалтын хоёр ахлах байцаагч батлагдсан орон тооны дагуу ажиллаж байна.

**Схем 1. Бизнес төлөвлөгөө болон батлагдсан бүтцийг харьцуулбал**



1.7 Бизнес төлөвлөгөөнд мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн чиг үүргийг дараахь байдлаар тусгажээ:

- Бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх
- Эрх зүйн бодлогын болон хуулийн хэрэгжилтийн явц, байдал, эрх зүйн үйлчилгээ мэдээллийн ажлын үр нөлөөнд хяналт шинжилгээ хийх
- үр дүнд нь үнэлгээ өгөх

1.8 Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн нэгжгүйгээс дээрх чиг үүрэг хэрэгжиж чадаагүй байна.


1.9 Тус газраас 2005 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил 98,5 хувь (буюу 4,9 оноо), бүтээгдэхүүн нийлүүлэлтийн

төлөвлөгөө 98,5 хувь (буюу 4,9 оноо) биелэлттэй байгаа ч ажлын үр дүнд хангалттай үнэлгээ хийгдээгүй байна.

1.10 2005 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд “Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд орчин үеийн шинжлэх ухаан техникийн ололт амжилтыг ашиглана” гэсэн бүтээгдэхүүний 2.3-т “... цахим хуудас нээх ажлыг зохион байгуулж [www.traffic-police.mn](http://www.traffic-police.mn) хаяг бүхий цахим хуудсыг боловсруулж, хэлтэс, тасаг, алба, алба-хаагч бүрийг цахим хаягтай болгох ажлыг зохион байгуулж туршилтаар ашиглаж байна.... Албаны үйл ажиллагаа, алба хаагчтай холбоотой санал асуулгыг сар бүр цахим хуудас ашиглан явуулж байх боломжийг судалж ажиллав” гэж тайлагнаад биелэлтийг 100 хувь гэж дүгнэжээ.

1.11 Гэтэл тус цахим хуудас одоогийн байдлаар ашиглах боломжгүй байна.

Зураг 1. Цахим хуудсыг нээж үзэхэд гарч байгаа байдал



**Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсронгуй болгож, гарч болох эрсдэлийг тодорхойлох шаардлагатай байна**

1.12 ЗЦГ 2004-2006 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөндөө орчны шинжилгээ хийж, байгууллагын давуу болон сул талыг тодорхойлжээ.

1.13 Хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилт тодорхойгүй, дэд зорилтууд нь хэмжих боломжгүй байна.

Тухайлбал, ЗЦГ стратегийн гуравдугаар зорилтыг хангах дэд зорилтыг дараахь байдлаар тодорхойлжээ:

Стратегийн **гуравдугаар зорилт** – Замын цагдаагийн албаны бүх шатны удирдлага цагдаагийн байгууллага, замын цагдаагийн байгууллагад тавигдаж буй нийгмийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан харж өөрчлөлт, шинэчлэлтийг цаг тухайд нь хийх мэдрэмж, чадвартай байх.

Үйл ажиллагааны зорилт **3.1** – Замын цагдаагийн албаны мэдрэмж, хариуцлагыг сайжруулна.

Үйл ажиллагааны зорилт **3.2** – Төв, орон нутгийн Замын цагдаагийн газар, хэлтэс, аймаг дүүргийн тасаг, албаны бүх шатны удирдлагад өөрийн болон хэлтэс, тасаг, алба нэгжийн ажилд судалгаа, шинжилгээ хийж, чиглэлээ оновчтой тодорхойлж, үйл ажиллагаагаа зөв зохион байгуулах чадвар эзэмшүүлнэ



1.14 Замын цагдаагийн удирдлага стратегийн төлөвлөгөөг дараахь бүдүүвчийн дагуу боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй байна:

- Дээд түвшний тодорхой зорилт дэвшүүлэх
- Үндсэн зорилтыг хангахын тулд хэмжиж болох зорилтуудыг боловсруулж ажилтнуудад мэдээлэх
- Зорилго, зорилтыг биелүүлэх тодорхой хариуцах эзнийг оноох
- Удирдлагын гурван түвшинд ахиц дэвшлийг тогтмол хянах
- Амжилттай гүйцэтгэсэн ажлыг зохих ёсоор цаг тухайд нь тэмдэглэж урамшуулах

1.15 Дээрх байдлаар өөрийн үйл ажиллагааны хэтийн зорилтоо тодорхойлон эрсдэлээ тооцож, үйл ажиллагаагаа явуулбал илүү үр дүнтэй байх боломж байна.


1.16 ЗЦГ-ын удирдлага өөрийн үйл ажиллагаанд авилгал, хүнд суртал, сонирхлын зөрчил байж болох талаар эрсдэлийн шинжилгээ хийгээгүй байна.

1.17 Нийтийн ашиг сонирхолд нийцсэн үйлчилгээг үзүүлж чадаж байгаа эсэх, эдгээрт ямар нэг ашиг сонирхолын нөлөөлөл гарч байгаа эсэх талаар өдөр тутам автозамын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарын дунд ангилалаар нь судалгаа явуулж, дүн шинжилгээ хийх нь зүйтэй байна.

1.18 Аудитын явцад хотын замын хөдөлгөөнд байнга оролцож байдаг, үр дагавар хамгийн өндөр байж болох магадлалтай бага оврын автобусны үйлчилгээ эрхэлдэг жолооч нараас дараахь асуудлаар санал асуулга авлаа. “ЗЦГ-ын ажилтнууд авилгал авдаг уу” гэсэн асуулгад 382 жолооч оролцож, 87,6 хувь нь авдаг гэж хариулсан байна.

1.19 “Авилгал авдаг бол аль шатны ажилтнууд авдаг вэ” гэсэн асуулгад жолооч нарын 67,6 хувь нь замын зохицуулагч (цагдаа) нар гэжээ.


График.1 “Авилгал авдаг бол аль шатны ажилтнууд авдаг вэ” асуулгын дүн



1.20 Түүнчлэн “Замын цагдаагийн зохицуулагч нар жолооч нарт ямар нэг дарамт үзүүлдэг үү” гэсэн асуулгад жолоочийн нарын дийлэнх нь дарамт үзүүлдэг гэжээ.

1.21 “Дарамт үзүүлдэг бол ямар дарамт үзүүлдэг вэ” асуултын хариуд 70,7 хувь нь “хэлж сануулж болох зүйлийг заавал торгодог” гэж үзжээ.

График.2 “Дарамт үзүүлдэг бол ямар дарамт үзүүлдэг вэ” асуулгын дүн



1.22 Судалгаанд хамрагдсан жолооч нарыг улсын хэмжээнд байгаа жолооны эрхтэй хүний тоонд харьцуулж үзэхэд асуулга хийсэн түүврийн хэмжээ бага боловч Улаанбаатар хотод бага оврын микроавтобусны үйлчилгээ эрхэлж, өдөр тутам замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарын 65-70 хувь энэ асуулгад оролцсон юм.

### Зөвлөмж

#### Замын цагдаагийн газрын дарга Ц.Амгаланбаярт:

- Өөрийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын чиг үүргийг оновчтой зохион байгуулах.
- Авилгал, залилан, сонирхлын зөрчил, хүнд суртал байж болох эрсдэлийн судалгаа хийж, урьдчилан сэргийлэх механизм бүрдүүлэх.

# Бүлэг 2

Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах боломж байна



## Танилцуулга


2.1 ЗЦГ 2005 онд батлагдсан орон тооноос 8 хүн дутуу буюу 453 хүнтэй ажиллажээ. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2005 оны 138 дугаар тушаалаар баталсан бүтэц, орон тоог үзүүлбэл:

Нэгжийн нэр	Офицер	Ахлагч	Энгийн	Бүгд
Тамгын хэлтэс	15	6	3	24
Жижүүрийн шуурхай алба	21	21		42
Хэрэг бүртгэх хэлтэс	17	1		18
Хөдөлгөөн зохицуулалтын хэлтэс	3	1		4
Хот хоорондын тасаг	4	9		13
Хамгаалалтын тасаг	11	27		38
Сүхбаатар дүүргийн ЗЦ-ийн тасаг	17	31		48
Чингэлтэй дүүргийн ЗЦ-ийн тасаг	18	31		49
Хан-Уул дүүргийн ЗЦ-ийн тасаг	16	31		47
Сонгинохайрхан дүүргийн ЗЦ-ийн тасаг	15	31		46
Баянгол дүүргийн ЗЦ-ийн тасаг	16	28		44
Баянзүрх дүүргийн ЗЦ-ийн тасаг	16	30		46
Замын зохион байгуулалт, хяналтын тасаг	4		1	5
Мэргэжил хяналтын тасаг	5	1	2	8
Техник бүртгэлийн тасаг	6		4	10
Гэрээгээр ажиллах ажилчид			17	17
<b>Бүгд</b>	<b>185</b>	<b>248</b>	<b>11</b>	<b>461</b>


2.2 Автозамын осол хэргийн тоо 2000 онтой харьцуулахад 22,6 хувиар буурчээ. Мэдээллийн сан дахь судалгаанаас үзэхэд нийслэл хотод тээврийн хэрэгсэл 1990 онтой харьцуулахад 6 дахин, 2000 онтой харьцуулахад 1,9 дахин өссөн байна.

График 3

2000-2005 онд УБ хотод гарсан ослын тоо



2000-2006 онд тоологдсон УБ хотын тээврийн хэрэгслийн тоо



2.3 Улаанбаатар хотын автозамын нийт урттай тээврийн хэрэгслийг харьцуулан үзэхэд 2000 онд 1 км-т дунджаар 114 тээврийн хэрэгсэл оногдож байсан бол 2006 онд дунджаар 195 тээврийн хэрэгсэл болж өсчээ.

2.4 2001 оноос осол гэмт хэргийн дуудлагад хүрэлцэн очих хугацаанд дүн шинжилгээ хийж, шуурхай болгох арга хэмжээ авсны үр дүнд хэргийн газар богино хугацаанд очих боломж 2004 оноос 4 орчим хувиар нэмэгджээ.

**Иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг тодорхойлон, хөнгөн шуурхай болгох боломжийг судалж, бүтцээ тодорхой болгох шаардлагатай байна**

2.5 ЗЦГ үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд хэрэглэгчээ дараахь байдлаар тодорхойлжээ.

Замын цагдаагийн албаны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаагийн газрын дарга байна.

2.6 Гэтэл тус алба замын хөдөлгөөнд оролцогч нийт иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд тус газрын үндсэн хэрэглэгч нь иргэд, олон нийт байгаа тул хэрэглэгчийг оновчтой тодорхойлох шаардлагатай байна.

2.7 ЦЕГ-ын даргын тушаалаар баталсан орон тоо, бүтцээс үзэхэд ЗЦГ улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байна уу, аль эсвэл зөвхөн нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байна уу гэдэг нь тодорхойгүй байна.

2.8 Тухайлбал, аймгуудын замын цагдаагийн тасаг тухайн аймгийн цагдаагийн хэлтсийн удирдлагад ажиллаж байна. Нийслэлийн Багахангай, Багануур дүүргийн замын цагдаагийн тасаг ЗЦГ-т хамааралгүй байна.


**Зөвлөмж**

ЦЕГ-ын дарга, хошууч генерал Д.Сандаг-Очирт

- ЗЦГ-ын бүтэц, зохион байгуулалтыг хянаж, оновчтой болгох

2.9 Аудитын явцад хийсэн “ЗЦГ-ын үйл ажиллагаа хүнд сурталтай байна уу” гэсэн санал асуулгад 389 жолооч оролцсоноос 93.0 хувь хүнд сурталтай гэж хариулсан байна. Мөн “Хүнд суртал байгаа бол албан тушаалын аль шатанд байгаа вэ” гэсэн асуултад 56,1 хувь нь “Замын зохицуулагч нар” гэж хариулжээ.

График 3. “Хүнд суртал байгаа бол албан тушаалын аль шатанд байгаа вэ” гэсэн асуулгын дүн



2.10 Дээрх асуулгаас үзэхэд иргэд ЗЦГ-ын анхан шатны нэгжээс үйлчилгээ хүлээн авахад хүнд суртал их байгааг шүүмжилсэн байна. Иймд хүнд суртлыг багасгах арга хэмжээ авах, үүний тулд юуны өмнө дүүргийн замын цагдаагийн тасгуудад ямар албан тушаалтан, хэддүгээр өрөөнд, ямар ажил эрхэлж байгааг дурдсан самбар гаргаж, санал хүсэлт хүлээн авах хайрцаг ажиллуулах хэрэгтэй юм.



2.11 Аймаг, дүүргүүдийн замын цагдаагийн тасгийн автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, бүртгэлийг хүчин чадал муутай Пентиум-2 компьютерт хөтөлж байгаа нь үйлчилгээний шуурхай байдлыг хангаж чадахгүй байна.

2.12 ЗЦГ-ын төвд байрлах мэдээллийн сантай дээрх компьютерууд утсан холбоо буюу “диал ап” холболтоор холбогддог нь үйлчилгээ удаашрах, иргэдийг бухимдуулах нэг нөхцөл болж байна.

2.13 Үүнээс шалтгаалан нийслэлийн дүүргүүдийн замын цагдаагийн тасгууд үдээс хойш 3 цагт бүртгэлээ дуусгаж, төв санд биеэр ирж бүртгэлээ дахин шивж оруулах, хөдөө орон нутгаас сар бүрийн эцэст мэдээ авч мэдээллийн санд дахин оруулах зэргээр үр ашиггүй ажил хийж байна.

2.14 Замын хөдөлгөөний хууль, дүрмийг замын цагдаагийн ажилтнууд бүрэн мөрдөхгүй байгаагаас иргэдэд зохих ёсны үлгэр үзүүлэхгүй байна. Тухайлбал, гар утсаар ярихдаа чихэвч ашиглахгүй байх, замын хөдөлгөөнд боловсон оролцож явган зорчигчдод зам тавьж өгөхгүй байгаа зэрэгт арга хэмжээ авахгүй байгаа нь жолооч нарт дүрмийг мөрдөхгүй байж болно гэсэн ойлголт төрүүлж байна.

2.15 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2005 оны 94 дүгээр тушаалаар хөдөлгөөнд саад учруулан зогссон автомашиныг ачуулах үйл ажиллагааг зохицуулах журмыг баталжээ. Үүний дагуу ЗЦГ “Баттех” ХХК, “Хос саран” ХХК, “Авто хяналт” ХХК-тай гэрээ байгуулж, дээрх компаниуд нэг тээврийн хэрэгслийг ачсаны хөлсөнд 25000 төгрөг авч байна.

2.16 Мөн хувийн компаний хашаанд дүрэм зөрчсөн автомашиныг журамлаж байх гэрээг ЗЦГ “Баттех” ХХК-тай байгуулж, нэг хоногт 3000 төгрөгөөр тооцож хөлс авч байна.

2.17 Үүний улмаас “ЗЦГ хувийн компанитай хамтран ашиг олох үйл ажиллагаа явуулж, сонирхлын зөрчил үүсгэж байна” гэсэн ойлголт иргэдийн дунд бий болжээ.


### **Зөвлөмж**

Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаярт:

- Автозамын хөдөлгөөнд саад учруулж байгаа автомашиныг ачих журмын хэрэгжилтийг шалгаж, дүнг олон нийтэд мэдээлэх;

### **Жолоочийн эрх олгох шалгалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна**

2.18 “Таны бодлоор жолооч бэлтгэдэг сургалтын чанар ямар байна вэ” гэсэн санал асуулгад 376 жолооч оролцсоноос 54,8 хувь дунд зэрэг гэж үзжээ.




2.19 Сургалтын чанар хангалтгүй гэсэн шалтгааныг дараахь байдлаар тайлбарлажээ.

- Хугацаа хэт богино
- Багш нарын заах арга зүй, мэдлэг дутмаг
- Чанаргүй дамжаа олширсон
- Сургалтын хөтөлбөр хангалтгүй
- Техник, тоног төхөөрөмж хангалтгүй
- Чанаргүй төгсөгчид их болсон

2.20 2005 онд нийслэлийн Хан Уул, Баянгол, Баянзүрх, Сонгино хайрхан, Чингэлтэй дүүргүүдэд гарсан 3557 осол, гэмт хэргийн 80 хувьд түүвэр хийж жолооч нь хэдэн онд дамжаа дүүргэсэн байдалд судалгаа хийж үзэхэд 48,1 хувь 2001-2005 онд эрх авсан жолооч нар байна.

График 4. 2005 онд дүүргүүдэд гарсан осол, гэмт хэрэг үйлдсэн жолооч нарын эрх авсан хугацаа



2.21 Сүүлийн 5 жилд 272652 хүн жолооны эрх авсан нь түүнээс өмнөх 10 жилд эрх авсан жолоочоос 2 дахин их байна.

2.22 2005 оноос Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар жолоочийн эрх олгох шалгалтыг аймаг, дүүргийн замын цагдаагийн тасгууд өөрсдөө хариуцаж

байхаар тогтоожээ. Энэ нь төвлөрлийг сааруулах талтай ч шалгалтын чанарт тавих хяналтыг сулруулах нөхцөл бүрдүүлсэн байна.

2.23 Дээрх нөхцөл байдлаас үзэхэд жолоочийн эрх олгох сургалтын явцад хяналт тавих үүрэгтэй УМХГ, шалгалт авч жолоочийн эрх олгодог ЗЦГ хяналтаа сайжруулах шаардлагатай байна.

### **Нийслэлийн автозамын хөдөлгөөнийг зохицуулах үйл ажиллагаанд хамааралтай байгууллагуудын хоорондын ажлын уялдаа хангалтгүй байна**

2.24 2005 онд нийслэлийн техникийн улсын тооллогоор 76149 тээврийн хэрэгсэл тоолуулсан байхад үүний дөнгөж 49,8 хувь буюу 37940 тээврийн хэрэгсэл оношлогоонд хамрагджээ. Үүнээс эрүүл ахуйн болон техникийн аюулгүй байдлыг бүрэн хангаагүй тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцсоор байна гэж үзэж болох юм.

2.25 Тухайлбал, Багануур, Налайх дүүргүүдэд техникийн хяналтын үзлэг, оношлогоо хийх газаргүйгээс зөвхөн тээврийн хэрэгслийн тооллого хийгдэж байна.

2.26 “Тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын үзлэг явуулах журам”-д Тээврийн хэрэгслийн тооллогыг ЗЦГ, техникийн хяналтын үзлэгийг Тээврийн газар зохион байгуулж явуулна гэж заажээ.

2.27 Түүнчлэн хотын замын гэрлэн дохио тогтмол ажиллахгүй байгаагаас түгжрэл үүсч иргэдийг бухимдуулж байна. Гэрлэн дохиог засварлаж байх үүргийг Улаанбаатар зам засвар УҮГ хүлээж байна.

### **Зураг 2 Их борооны үеэр ажиллахгүй байгаа гэрлэн дохио, машины түгжрэл**



(нэгдүгээр 40,000-ын “Эрэл банк”-ны уулзвар 2005.05.29 9:05 )

2.28 Нийслэлийн автозамын хөдөлгөөнийг зохицуулах үүрэгтэй байгууллагууд хоорондын ажлын уялдаа холбоо муугаас бүрэн бус техник, эрүүл ахуй, байгаль орчны шаардлага хангахгүй тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцож гэрлэн дохио үе үе ажиллахгүй байгаагаас гэмт хэрэг, осол гарах, түгжрэл үүсэх, улмаар иргэд эрүүл мэндээрээ хохирох, бухимдах явдал гарч байна.

### **Зөвлөмж**



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Батбаярт:

- Автозамын хөдөлгөөний зохицуулалт хийдэг байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулж, Улаанбаатар хотын замын түгжрэлийг багасгах бодлого боловсруулах.

## Бүлэг 3

Санхүүжилтийн эх үүсвэрийн хоёрдмол байдлыг цэгцлэх хэрэгтэй байна




### 1.Танилцуулга

3.1 Цагдаагийн ерөнхий газар болон Нийслэлийн Засаг даргын давхар удирдлагад Замын Цагдаагийн Газар харъяалагдаж, хөдөлгөөн зохицуулалтын, тамгын, жижүүрийн шуурхай албаны хэлтэс, замын зохион байгуулалт-хяналтын, мэргэжил хяналтын, техник бүртгэлийн тасаг, нийслэлийн 6 дүүрэгт замын цагдаагийн тасагтай үйл ажиллагаагаа гүйцэтгэж иржээ.

3.2 Замын цагдаагийн газарт 2005 онд улсын төсвөөс 98,1 сая, төлбөртэй үйлчилгээгээр 20,0 сая, бүгд 118,1 сая төгрөг, нийслэлийн төсвөөс 734,6 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоор 64,6 сая, бүгд 799,2 сая, нийт 917,3 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

3.3 Замын цагдаагийн газар 2005 онд улсын төсвөөс 79,6 сая, төлбөртэй үйлчилгээнээс 20,6 сая, бүгд 100,2 сая төгрөг, нийслэлийн төсвөөс 734,6 сая, бусад төсөвт байгууллагаас 5,7 сая, тусгай зориулалтын сангаас 17,5 сая, олон улсын байгууллагаас 3,0 сая, гэрээний хөлсөнд 44,1 сая, үндсэн үйл ажиллагааны орлого 184,4 сая, үндсэн бус үйл ажиллагааны орлого 52,7 сая, бүгд 1042,0 сая, нийт 1142,2 сая төгрөгийн санхүүжилттэй ажиллажээ.

График 5. ЗЦГ-ын орлогын бүтэц



3.4 Төсөвт байгууллагын үйл ажиллагааны өмнөх оны орлогын гүйцэтгэл 251,3 сая төгрөг байхад 2005 оны орлогыг 84,6 сая төгрөгөөр төлөвлөж орлогын төлөвлөгөө 173,2 сая төгрөгөөр давж биелсэн байна.

3.5 Тайлант хугацаанд мөнгөн гүйлгээний дансаар 1142,2 сая төгрөгийн орлогын гүйлгээ, 916,8 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгджээ.

3.6 Нийслэлийн Засаг даргын захирамжаар үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос нэмж санхүүжүүлсэн боловч төсөвт тодотгол хийгээгүй байна.

### Шатахууны зардлыг давхардуулан олгожээ

3.7 2005 онд Замын цагдаагийн газрын хөдөлгөөнт эргүүл хяналтын 22 автомашинд Улсын баяр наадмын комиссоос шатахууны зардлыг тооцож олгосон байтал тус газраас шатахууны зардлыг давхардуулан 730,0 мянган төгрөг олгосныг холбогдох хэлтэс, тасгийн ажилтнуудаар төлүүлэхээр акт бичив.

3.8 Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 266 дугаар тогтоол, Хууль зүйн сайдын 1997 оны 31, Цагдаагийн Ерөнхий Газрын 2000 оны 321, "Жишиг норм батлах тухай" Дэд бүтцийн сайдын /хуучин нэрээр/ 2004 оны 19 дүгээр тушаалаар батлагдсан шатахууны лимитийг 50402 км-ээр хэтрүүлж, 43665 литр шатахуун илүү зарцуулсны үнэ 3486,1 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлэхээр акт бичив.

3.9 2005 оны эцэст кассад 13,2 сая, харилцах дансанд 227,6 сая, бүгд 240,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь Замын цагдаагийн ажилтны автобусаар зорчих тээврийн хөлсний нөхөн олговрыг 2004 онд Нийслэлийн тээврийн газарт шилжүүлэхдээ 2005 оныхыг урьдчилж төлсөн, мөн дээр дурдсан орлогын төлөвлөлттэй холбоотой байна.

3.10 Замын цагдаагийн ажилтнуудын тээврийн хөлсний нөхөн олговорт зориулж олгосон хөрөнгөнөөс Нийслэлийн Засаг даргын 2005 онд 358 дугаар захирамжаар нийтийн тээврийн хэрэгсэл зогссон үед шөнийн цагаар цагдаагийн ажиллагсдыг ар гэрт нь хүргэхэд шаардагдах автомашин худалдан авахад зориулж Замын цагдаагийн газарт 12,5 сая төгрөгөөр автобус худалдан авч өгчээ.


3.11 Цагдаагийн ажилтнуудын нийтийн тээврийн хэрэгслээр зорчиход зориулагдсан хөрөнгө ийнхүү зориулалт бусаар зарцуулагдаж байгаа учраас Нийслэлийн тээврийн газарт олгодог тээврийн нөхөн олговорт зориулсан хөрөнгийг цагдаа нарт олгож, нийтийн тээврээр цагдаа нарыг төлбөртэй зорчуулах нь зүйтэй байна.

### Орлого нэмэгдүүлэх боломж байна

3.12 1999 онд Цагдаагийн Ерөнхий Газар "Ай Эс Си" Монголия" ХХК-тай Монгол Улсын жолооч нарын тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэх олгох ба бүртгэх системийг суурилуулах, зүгшрүүлэх ДЛС системд 2000 онд шилжих шаардлагыг хангах, нэмэлт тоног төхөөрөмжөөр тоноглож ажилд оруулах талаар гэрээ байгуулжээ.

3.13 Уг гэрээнд заахдаа жолоочийн үнэмлэхний үнийг 10 ам.доллар эсвэл түүнтэй тэнцэх үндэсний валютаар тогтоосон ба ам доллартай харьцах үндэсний валютын албан ёсны ханш 5 хувиар өөрчлөгдөх бүрд үнэмлэхний үнэд зохицуулалт хийхээр тусгасан бөгөөд өнгөрсөн хугацаанд үнийн өөрчлөлт 1 удаа хийсэн байна.

График 5. 2000-2006 онд хэвлэгдсэн жолооны үнэмлэхний тоо, үнийн дүн



3.14 Дээрх графикаас харахад өнгөрсөн хугацаанд 367400 ширхэг жолоочийн үнэмлэх хэвлэснээс 4529,7 сая төгрөгийн борлуулалтын орлого "Ай Эс Си" ХХК-д, жолоочийн үнэмлэхийн анхааруулах талоныг "Би-И-Си" ХХК-тай гэрээ байгуулан хийлгэснээс 642,9 сая төгрөгийн орлого тус компанид төвлөрсөн байна.

3.15 Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан гэрээний хугацаа дуусаад 6 сар өнгөрсөн / **1999 оны 12 дугаар сарын 20-ны өдөр 6 жилийн хугацаатай**

**байгуулсан/** боловч уг гэрээ өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Ийм учраас энэ гэрээг сунгах эсэх асуудлыг зохих байгууллагууд судалж үзэх, жолоочийн үнэмлэх, талоныг төр өөрийн мэдэлдээ авч хэвлэвэл төсвийн орлого багагүй нэмэгдэх нөөц боломж байгааг анхаарах нь зүйтэй байна.

### **Нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтлөөгүй байна**

3.16 ЗЦГ 2004 оны жилийн эцэст 63,4 сая төгрөгийн авлагатай байснаас 2005 оны эцэст 10,4 сая төгрөг болж авлага 53,0 сая төгрөгөөр буюу 83,6 хувиар буурч, өглөг оны эхэнд 38,5 мянган төгрөг байснаас 140,0 мянган төгрөгөөр өссөн байна. Авлага 2005 онд буурсан тухайд гэвэл 2004 оны жилийн эцсийн харилцах дансны үлдэгдлийг ХЗДХЯаманд шилжүүлж "хий" авлага үүсгэн үүнийгээ буцааж авснаар дансны бичилт хийснээс нь авлага буурсан харагдаж байгаа юм.

3.17 Замын цагдаагийн газар улсын болон нийслэлийн төсвөөс санхүүжилт авч санхүүгийн тайлан тэнцлийг эх үүсвэр тус бүрээр гаргаж иржээ. Харин санхүүгийн нөөц, үр ашгийг тооцоход нэгдсэн тайлан тэнцэл гаргах шаардлагатай байна. Учир нь, тус газар улсын төсвөөс болон нийслэлийн төрийн сангаас авсан санхүүжилтээр гаргасан тайлан тэнцэлдээ үндсэн хөрөнгө, авлага, өглөгийг зэрэг тусган харуулжээ.

3.18 Нягтлан бодох бүртгэлийн хувьд тайлан тэнцлийг хуулийн хугацаанд тайлагнасан боловч зардлыг аккруэл сууриар бүртгээгүй мөнгөн сууриар бүртгэж ирснээс бүртгэлд бодитой тусгагдахгүй байна.

3.19 Тухайлбал, 2005 онд Нийслэлийн тээврийн газарт цагдаагийн ажилтнуудын нийтийн тээврээр зорчих унааны нөхөн олговрыг 2004 онд шилжүүлснийг "Урьдчилж гарсан зардал" дансанд бүртгэлгүй шууд зардалд бичжээ.

3.20 Тус газар 2005 онд Хан-Уул дүүргийн Замын цагдаагийн тасгийн болон архивын барилгыг тендер зарлаж бариулсан байна. Харин үндсэн хөрөнгө болон техник, тоног төхөөрөмж авахдаа үнийн судалгаа гарган ЗЦГ-ын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу худалдан авчээ.

3.21 Монгол Улсад оршин сууж буй гадаадын байгууллага, иргэдэд олгосон жолоочийн үнэмлэх, талон, автомашины дугаарын төлбөрөөс орж байгаа орлогыг бэлнээр хураан авч, өөртөө үлдэх хэсгийг орлогод тусгаж, бусад байгууллагад олгох орлогыг дансанд тусгалгүй зарцуулдаг нь нягтлан бодох бүртгэлийн хуулийг зөрчиж байна.

3.22 Замын цагдаагийн газар бүтээгдэхүүний өртгийн тайланг тооцож гаргаагүй байна.

3.23 Замын цагдаагийн газар 222552 ширхэг торгуулийн хуудсаар 360,1 сая, 13243 ширхэг шийтгэврийн хуудсаар 152,3 сая, бүгд 512,5 сая төгрөгийг нийслэлийн төрийн санд төвлөрүүлжээ.

3.24 Тус газрын хувьд дүүргүүдийн замын цагдаагийн тасагт олгосон торгууль, шийтгэврийн хуудасны тооцоог сар бүр тооцож ирсэн байна.

**Зөвлөмж:****Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаярт:**

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад цагдаагийн ажилтнуудын унааны зардлын хөнгөлөлтийг нөхөхөд зориулж батлагдсан хөрөнгийг цагдаагийн ажилтнуудад олгох асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
- ЗЦГ-ын санхүүжилтийн эх үүсвэрийг нэг мөр болгох асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;


**Цагдаагийн Ерөнхий Газрын дарга, хошууч генерал Д.Сандаг-Очирт:**

- "Ай-Эс-Си" ХХК-ийн хэвлэж байгаа жолоочийн үнэмлэхийг төрийн мэдэлд авах асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

**Замын цагдаагийн газрын дарга Ц.Амгаланбаярт:**

- Үндсэн үйл ажиллагаанаас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж төсөвт тусгуулах;
- Нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлан тэнцлийг аккрузал сууриар бүртгэн тайлагнаж байх.

# Холбогдох байгууллагын санал



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ**  
**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**  
**ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР**


210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж, Утас/факс: 32-36-11

2006.06.27 № 111-894  
танай 06.06.27-ны № 1281 -г

┌ **ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ** ┐

Санал хүргүүлэх тухай

Замын Цагдаагийн газарт хийсэн шалгалтын тайлантай танилцав. Цаашид холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.



**ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА** **Ц.АМГАЛАНБАЯР**



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2006 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг.Замын цагдаагийн газрын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөт байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д заасны дагуу аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав.Аудитын тайланг УИХ-ын Хууль зүйн Байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Д.Сандаг-Очир, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Батбаяр, Замын цагдаагийн газрын дарга, хурандаа Ц.Амгаланбаяр нарт хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитын тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч түүний үр дүнг 2006 оны 10 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Замын цагдаагийн газрын дарга, хурандаа Ц.Амгаланбаярт зөвлөсүгэй.



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

*Л.Жавзмаа*

Л.ЖАВЗМАА

073183

tushaal



Монгол Улсын Ерөнхий аудиторовын  
2006 оны 7 дугаар тушаалын  
хавсралт

Замын Цагдаагийн Газарт хийсэн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

УТЛА0122

Төгрөгөөр/

№	Нэр	Төлбөр хариуцагчийн		Төлбөр, зөрчлийн товч утга	Ахтын дугаар	Төлбөрийн дүн	Үүнээс	
		Албан тушаал	Албан тушаал				төсөвт	байгууллагад
1	Ц.Амгаланбаяр М.Батчимэг	Замын Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа	Замын Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэслэгч	Хүн амын орлогыг төсөвт төвлөрүүлэх тухай	5	105210.0	105210	
2	Ц.Амгаланбаяр М.Батчимэг	Замын Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа	Замын Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэслэгч	Норм хэтрүүлсэн шахаууны үнийг төлүүлэх тухай	6	3486177.0	3486177.0	
3	Ц.Амгаланбаяр М.Батчимэг	Замын Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа	Замын Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэслэгч	Давхардуулж олгосон шахаууны үнийг төлүүлэх тухай	7	730000.0	730000.0	
		Нийт дүн		xxx	xxx	4321387.0	4321387.0	

Үндэсний аудитын газар